

Шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчмын хэрэгжилт

Implementation of the principle of open decision of court cases

Мэндбаярын Долгорсүрэн¹

Магистр

Шинжлэх Ухааны Академсийн

Философийн хүрээлэн

Улс төр, эрх зүйн салбар

angelnice999888@gmail.com

Dolgorsuren Mendbayar

Master of Arts

Department of Political Science & Legal

Studies, Institute of Philosophy,

Mongolian Academy of Sciences

angelnice999888@gmail.com

Хураангуй:

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлээр Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлт, 2021 онд баталсан Шүүхийн тухай хууль, шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчмын эрх зүйн зохицуулалт болон эрх зүйн баримт бичгүүд, шүүх хуралдааны явцыг олон нийтэд шууд дамжуулах гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, туршилага, жишгийг судалж, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорьлоо. Эрдэм шинжилгээний өгүүллийг гүйцэтгэхдээ үндэсний болон олон улсын эрх зүйн баримт бичгийн шинжилгээ, агуулгын шинжилгээ, ажиглалтын арга зүй болон социологийн судалгааны арга, мөн судалгааны харьцуулалтын болон задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргыг ашигласан.

Ил шүүх хуралдаанд оролцох эрх хангагдсан байдал 2010 онд хийсэн анхны ажиглалтын дүнг 2015 оны судалгаатай харьцуулахад тусгайлан зөвшөөрөл авах явдал 1 хувиар буурсан үзүүлэлт харагдаж байгаа боловч шүүх хуралд ороход 23.3 хувьд нь ямар нэг зөвшөөрөл шаардаж байгаа нь шүүх хуралдааныг ил явуулах зарчим бүрэн хэрэгжиж байна гэж дүгнэх боломжгүй бөгөөд ил байдал хангалтгүй байгааг илтгэж байна.

Түлхүүр үгс: Шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчим, эрх зүйн зохицуулалт, эрх зүйн баримт бичиг, хэрэгжилт

Abstract:

In this academic article, the amendments to the Constitution of Mongolia in 2019, the Law on Courts adopted in 2021, the legal regulations and legal documents on the principle of open court cases, and the legal regulations of some foreign countries that broadcast court proceedings live to the public. We aim to study regulations, experience, and standards and propose proposals for improving its legal framework. The analysis of national and international legal documents, content analysis, observational methodology and sociological research methods, as well as comparative, analytical and summarizing research methods were used in the execution of the research article. The right to participate in open court hearings.

The results of the first observation conducted in 2010 compared to the 2015 survey showed a decrease of 1 percent in obtaining special permission, but 23.3 percent of the cases require some kind of permission to enter the court hearing, so it can be concluded that the principle of open court hearings is fully implemented. is not possible and indicates insufficient exposure. In the era of rapid social development and technological progress, the need to further improve the principle of open court cases, except for those specifically provided by law, is always a priority.

Keywords: Principles, legal regulations, legal documents and implementation of open court cases

¹ © Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

I. Оршил

Төрийн үйл ажиллагаа түүн дотроо шүүх хэргийг ил шийдвэрлэх зарчмын асуудал, шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт тэдгээрт олон нийт болон иргэний нийгмийн зүгээс тавих хяналтыг сайжруулахыг нийгмийн хөгжил шаардаж байна. Шүүх хуралдааныг ил явуулах нь шүүхийн бие даасан, шударга байх нэгэн чухал үзүүлэлт бөгөөд шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бататган нэмэгдүүлэх хамгаалалт болдог. Зарим нэг онцгой тохиолдлоос бусад үед шүүх хуралдааныг ил явуулах эрх зүйн зохицуулалттай. Энэ нь мөн олон улсын стандартад тусгагдсан байдаг. Шүүх хуралдааныг ил явуулах нь зөвхөн хэргийн талуудад хамаараад зогсохгүй олон нийтийн эрх ашигт хамааралтай асуудал юм. Олон нийт шударга байдал хэрхэн тогтож байна вэ?, шүүх үйл ажиллагаа ямар шийдвэрт хүрэх гэдгийг мэдэх эрхтэй байдаг билээ. Эрт дээр үед ч гэсэн шүүн таслах ажиллагааг ил таслан шийдвэрлэх нь олон нийтийг илүү шударга, тэгш эрх, шүүхийн ил тод байдлыг хангах үзэл санаа нь илт давамгайлж ирсэнийг судлаачид тэмдэглэсэн байдаг. Үндсэн хуулийн үзэл санаа болохын хувьд дахин сэргэлтийн үеийн сэтгэгчид болох Ш.Л.Монтесье, И.Кант, Ф.Бекон нарын онол, бүтээлүүдээс эх үндэстэй бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хуульд тусгагдсанаар улам боловсронгуй болж хөгжих эрх зүйн үндэс нь тавигдсан. Уг үзэл санааны гол агуулга нь ардчиллын хийгээд Үндсэн хуульт ёсны үнэт зүйл болох шударга ёс, ил тод, нээлттэй байдлыг хангах үйл явцтай уялдаа холбоотой бөгөөд эдгээрийг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч эдгээдээс үйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлж, сахин хамгаалж байгаад иргэд, олон нийтийн зүгээс хяналт тавих нээлттэй боломжийг хангах байдлаар илэрхийлэгддэг[1]. Шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчмын хэрэгжилтийн хүрээнд ННФ “Шүүх хуралдааны ажиглалтын судалгааны нэгдсэн тайлан” (Уб., 2017), ХЗҮХ “Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварыг үнэлэх үнэлгээний тайлан” (Уб., 2018), ШЕЗ “Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгааны тайлангын эмхэтгэл. (Уб., 2015, 2016), УДШ-ийн ерөнхий шүүгч Д.Ганзориг. Шүүхийн шинэтгэл. бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага. илтгэл. (Уб., 2021), Б.Өлзийсайхан “Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэл (Уб., 2022), Б.Даваажав “Шүүх хуралдааны аюулгүй байдал ба шүүх хуралдаан нээлттэй явуулах хууль зүйн харилцан хамаарлын зарим асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэл (Уб., 2010), Хууль зүйн үндэсний хүрээлэн, Германы хамтын ажиллагаа. “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” хавсралт тайлан. (Уб., 2016), Lorraine H.Tong, “Televising Supreme Court and other Federal Court Proceedings: Legislation and Issues” (November 8, 2006) зэрэг бүтээлүүдэд хэсэгчилэн судлан авч үзсэн байна. Шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчмын үндсэн үзэл санаа бодит байдалд хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэх, тулгарч буй сорилт, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нь шүүхийн шинэтгэлийг улам төгөлдөржүүлж, үр дүнтэй болгоход ач холбогдолтой.

II. Судалгааны арга зүй

Шүүхийн ажиглалтын арга зүйг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчиллын институт, хүний эрхийн байгууллагаас Зүүн Европын болон Төв Азийн хэд хэдэн оронд амжилттай хэрэгжүүлсэн Шүүхийн мониторингийн арга зүйд тулгуурлан боловсруулсан. Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх процессын хувьд гарах шийдвэр нь хувь хүнийг гэм буруутай гэж үзэн үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах нөхцөл байдал үүсдэг тул олон улсад эрүүгийн шүүх хуралд түлхүү ажиглалт хийдэг ажээ. Баримт бичгийн судалгаа: Үндэсний болон олон улсын эрх зүйн баримт бичгийн шинжилгээ, агуулгын шинжилгээ, ажиглалтын арга зүй болон социологийн судалгааны арга, мөн судалгааны харьцуулалтын болон задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргыг ашигласан. Судалгаанд холбогдох статистик мэдээлэл, одоо хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр болон эрх зүйн зохицуулалт, эрх зүйн шинжилгээ хийж холбогдох хэсгүүдэд ашиглав.

Шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчмын эрх зүйн зохицуулалт: Монгол Улсын Үндсэн хуулийн 54 дүгээр зүйлд “Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ” гэж заасан бөгөөд 2021 онд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай шинэчилсэн найруулга хуулийн 12 дугаар зүйлд “Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байна. Шүүх хуралдааныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулна. Хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хуралдааны явцын дууны, дуу-дүрсний бичлэгийг зохих журмын дагуу баталгаажуулж, архивт хадгална. Шүүх өөрийн цахим хуудастай байх бөгөөд шийдвэр, үйл ажиллагаагаа олон нийтэд тогтмол мэдээлнэ. Шүүх хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухай төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд мэдээлнэ” гэж зохицуулсан нь энэхүү үзэл санаа нь хууль зүйн хүчин чадалтай болж баталгаажиж, шүүх хуралдаан хуулиар хориглосноос бусад тохиолдолд ил явагдах, шүүхийн шийдвэртэй олон нийт танилцахад ил тод байх гэсэн утга санааг илэрхийлж байна. Энэ нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан хэм хэмжээтэй нягт уялдаа холбоотойгоор бусад салбар эрх зүйд тусгагдан хэрэгжиж байна. Үндсэн хуулийн процесст: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, тус хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэц маргаан хянан шийдвэрлэхдээ хуралдааныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд илээр, шууд, тасралтгүй явуулах, талуудыг эрх тэгш, чөлөөтэй мэтгэлцүүлэх, асуудлыг хамтран хэлэлцэж, олонхийн саналаар, бодитой, энэ хууль болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд чанд нийцүүлэн шийдвэрлэх зарчмыг баримтална” гэж тусгасан бол Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг ил тод явуулна. Төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг хангах онцгой шаардлагатайгаас бусад тохиолдолд Цэцийн хуралдааныг нээлттэй хийнэ” гэж зохицуулжээ.

Иргэний процесст: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна”. Мөн хуулийн 8.2 дахь хэсэгт “Хэргийн нотлох баримт, эсхүл үйл явдал төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн буюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно”.

Эрүүгийн процесст: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна”. Тус хуулийн 3.2.2 дахь хэсэгт “өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын ялагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно”. Мөн хуулийн 3.2.3-т “шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсоно”. Уг хуулийн 34.6 дахь хэсэгт “Өсвөр насны шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын ялагч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно”. Тус хуулийн 36.10 дугаар зүйлийн 1-т “Шүүх хуралдааныг нээлттэй явуулсан бол шүүх хуралдаан даргалагч энэ хуулийн 36.1 дүгээр зүйлийн 5.1, 5.2, 5.3, 5.4-т заасан асуудал тус бүрээр шүүхийн шийдвэрийг уншиж сонсоно”.

Захиргааны процесст: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна”. Энэ хуулийн 101.2 дахь хэсэгт “Захидал харилцааны мэдээллийг хамгаалахын тулд хувийн захидал, бичгийг тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгөөр нээлттэй шүүх хуралдаанд уншин сонсож болно” гэж зохицуулсан байна. Шүүх хуралдаан ил явуулах Үндсэн хуулийн үзэл санаа процессын эрх зүйн салбар бүрт өөрөөр хэрэглэгдэх байдал ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл шүүх хуралдаан нээлттэй буюу хаалттай явуулах хууль зүйн үндэслэлийн асуудал хоорондоо зарчмын зөрүүтэй байгааг анхаарах шаардлагатай байна[2].

Үндсэн хуулийн хавсралт хуулиар Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх тухайн байгууллагын тогтолцоог шинэчлэх ажлын хүрээнд Монгол Улсын Шүүхийн байгууламжийн тухай хууль болон Монгол Улсын Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн тухай хуулийг 1993 онд тус тус баталсан. Шүүх эрх мэдлийн хуулийг шинэчлэн баталснаар Монгол Улсын хууль тогтоох байгууллагаас Улсын Их Хурлын 1998 оны Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр,* үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах тухай 18 дугаар

* Үндсэн хууль 1992 онд батлагдан нийгмийн харилцааг зохицуулж байсан хууль тогтоомжийг бүрэн шинэчилэх ажил эхлээд богино хугацааны бодлогын баримт бичгийн биелэлтийг дүгнэх хугацаатай адилтган авч үзвэл залгамж чанар бүхий 2 баримт бичгийн хэргжилтийг үнэлэхүйц хугацаа /6 жил/-ны дараа Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн байна.

тогтоол, Улсын Их Хурлын 2000 оны Монгол Улсын Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө батлах тухай 39 дүгээр тогтоол, Улсын Их Хурлын 2003 оны Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай 41 дүгээр тогтоолоор тус тус баталсан эрх зүйн баримт бичигт шүүх эрх мэдлийн үзэл баримтлал, үндсэн чиглэлийг тусгаж ирсэн байна. Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр[3]-ийн төрийн байгууллын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох хүрээнд шүүх эрх мэдлийн хүрээн дэх нийт байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон өөрийн орны нөхцөл байдалд нийцүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүх ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг судлан үзэж боловсронгуй болгох арга хэмжээ авах зэрэг зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэн ажиллаж иржээ.

Улсын Их хурлаас 2000 оны 39 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө[4]-нд хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчимтай холбоотой шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа, шийдвэрийг олон түмэнд ил тод, хүртээлтэй, нээлттэй байлгах, шүүхийн үйлчилгээг эдийн засгийн хувьд хүртээмжтэй болгох, шүүн таслах ажиллагааны менежментийг боловсронгуй болгох зэрэг стратеги зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлж ирсэн байна. Тус стратеги төлөвлөгөөний Шүүх эрх мэдлийн байгууллагыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн нөлөөллөөс хараат бус байх нөхцөл бүрдүүлэх стратеги зорилтын хүрээнд шүүх эрх мэдлийн байгууллагууд иргэд, олон нийтэд зориулсан мэдээлэл боловсруулах, түүнийг тогтмол хүргэж байх мэдээллийн технологи бий болгох, шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааг олон түмэнд ил тод байлгаж, хуулиар тусгайлан нууцад хамааруулаагүйгээс бусад мэдээ, мэдээллийг чөлөөтэй олгох үүрэг бүхий хэвлэл мэдээллийн албадыг төв байгууллагууд дээр бий болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний хэрэг, маргааныг шүүхээс гадуур шийдвэрлэх арга механизмыг өргөжүүлэх, боловсронгуй болгох стратеги зорилтын хүрээнд ээдрээ төвөг багатай хэрэг, маргааныг чирэгдэл багатай, бага хугацаанд шийдвэрлэх арга зам бий болгох, зарим орны шүүхийн практиктай танилцаж, нэвтрүүлэх боломжтой эсэхийг судалж шийдвэрлэх зэрэг арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн байна[5]. Тус стратеги төлөвлөгөөнд шүүх эрх мэдлийн байгууллагад хандаж байгаа аливаа этгээдэд шүүхээс хүндрэл, чирэгдэл багатай, түргэн шуурхай, хямд зардалтай хүртээмжтэй үйлчилгээ хүргэх, шүүх эрх мэдлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх хуулиудыг боловсронгуй болгох стратеги зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэн ажиллажээ. Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний олон нийтийг эрх зүйн мэдээллээр хангах ажлыг өрнүүлэх, иргэний нийгэмтэй харилцах харилцааг боловсронгуй болгох стратеги зорилтын хүрээнд олон нийтэд эрх зүйн мэдлэг олгох мэдээлэл хүргэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэл /сонин, сэтгүүл, телевиз, радио/-тэй хамтран ажиллах механизм төлөвшүүлэх, олон нийтэд зориулан Улсын Дээд Шүүхээс гаргасан хуулийн тайлбар, Улсын Дээд Шүүхийн тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн

систем www.legalinfo.mn вэбсайтыг бий болгож ажиллуулсан байна. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn вэбсайтад Монгол Улсын хууль, олон улсын гэрээ, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, Улсын Дээд шүүхийн тогтоол, сайдын тушаал, Засгийн газрын агентлагийн даргын тушаал, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж зэрэг эрх зүйн 11670[6] акт байршуулж олон нийтийн хүртээл болгоод байна. Тус стратеги төлөвлөгөөнд шүүхүүдийн байршил, орон тоонд тавих шаардлага, стандартыг боловсруулж мөрдөх стратеги зорилтын хүрээнд шүүхийн үйлчилгээг хэрэглэгчдэд ойр дөт байхаар байршлыг нь тогтоох арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа, шийдвэрийг олон түмэнд ил тод, хүртээлтэй, нээлттэй байлгах стратеги зорилтын хүрээнд иргэд, хуулийн байгууллагад хандах, хуулийн байгууллагаас гарсан шийдвэртэй цаг алдалгүй танилцах боломжийг хангах, энэ үйл ажиллагаанд гарах чирэгдлийг арилгахад чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Тус стратеги төлөвлөгөөнд шүүн таслах ажиллагааны менежментийг боловсронгуй болгох стратеги зорилтын хүрээнд иргэдэд учирч болох бэрхшээлийг багасгах үүднээс шүүхэд хандаж гаргах бичиг баримтын эх загвар, маягыг нэгдсэн стандартад оруулах, шүүхийн менежментийн асуудлыг мэргэжлийн түвшинд хариуцаж гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэж ажилуулах, шүүхүүдийг компьютерийн нэгдсэн сүлжээнд холбох зэрэг шүүн таслах ажиллагааг боловсронгуй болгох чиглэлийн судалгаа хийж, цахим шүүх хурал зохион байгуулах холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт[7] хүний хувийн эрх, эрх чөлөөг хамгаалах, баталгаажуулахад анхан шатны шүүхийг байршлын хувьд иргэдэд ойртуулах, дагнасан шүүх байгуулах, шүүгчдийн тоог нэмж мэргэшүүлэх хэлбэрээр шүүхийн хүртээмжийг дээшлүүлэн иргэд шүүхэд гомдлоо гаргах бололцоог өргөтгөх зорилт дэвшүүлсэн байна. Шүүхийг хүн амд ойртуулж, тэднээс эрхээ хамгаалуулах, нэхэмжлэл, гомдол гаргах, шийдвэрлүүлэх боломж, нөхцлийг сайжруулах зорилгоор бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан зарим аймагт сум буюу сум дундын шүүх шинээр байгуулах, давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар ажиллуулах асуудлыг судалж шийдвэрлэх, хүний эрх зөрчсөн засаг захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд гарсан нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх эрх бүхий захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулж ажиллуулах зэрэг зорилт дэвшүүлэн хэрэгжүүлжээ. Үндэсний хөтөлбөрт шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, энэ талаар иргэд, хэвлэл мэдээллийн ажилтны хүсэлт шаардлагаар мэдээлэл гаргаж өгөх үүрэг, хариуцлага, иргэдээс мэдээлэл олж авах, түгээх эрхийг нь нарийвчлан тодорхойлсон хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлжээ.

2010 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр дэмжигдсэн “*Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр*”, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2004 оны 70 дугаар тогтоолоор баталсан “*Монгол Улсын шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал*”, мөн зөвлөлийн 2009 оны

15 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын шүүхийн мониторингийн үзэл баримтлал”, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2011 оны 39 дүгээр захирамжаар баталсан “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийг шүүхэд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх үндсэн чиглэл” зэрэг эрх зүйн баримт бичиг баталж, шүүн таслах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх, шүүн таслах ажиллагаанд хандах иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, иргэдэд шүүхээс үзүүлэх үйлчилгээг ойлгомжтой, хялбар, хүртээмжтэй болгох зорилтуудыг дэвшүүлж, шинэтгэлийг гүнзгийрүүлжээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар дэмжсэн “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор “Шүүхийн шийдвэрийн цахим сан” /www.shuukh.mn/-г 2011 оноос нэвтрүүлэн ажиллуулж эхэлжээ. Мөн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 39 дүгээр захирамжаар баталсан “Үндсэн чиглэл”-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.4.2, 1.4.3-г “Шүүхийн байгууллагаас иргэд, олон нийтэд зориулсан мэдээлэл боловсруулах, түгээх үйл ажиллагааг сайжруулах замаар шүүх, шүүгчийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодит мэдээллийг хүргэх чадавхыг бэхжүүлэх, шүүхийн шийдвэрийг цахим хуудсанд байршуулж олон нийтийн хүртээл болгох” гэж заасны дагуу бүх шатны шүүхийн шийдвэрийг нэгдсэн цахим санд байршуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж олон нийтэд хүргэж эхэлсэн байна[8]. Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах нь шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байлгах, шүүгч, эрдэмтэн, багш, судлаач, шинжээч, хуульчдад судалгааны ажил хийх, оюутан сурагчдад гарын авлага болгох, хуулийг нэг мөр, зөв хэрэглэх, жишиг тогтоох ач холбогдолтой. Уг ажлыг хэрэгжүүлснээр улсын хэмжээнд нээлттэй явагдсан шүүх хуралдаанаас гарсан бүх шийдвэрийг, хаалттай явагдсан хуралдаанаас гарсан шийдвэрийн хувьд зөвхөн тогтоох хэсэгтэй танилцах боломжтой. Уг цахим санд 2011 оноос хойшхи нийт анхан шатны шүүхийн шийдвэр, тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэх (цагаатгах) тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол зэрэг нийт 282160 хэргийн 389172 шүүхийн шийдвэр байршуулсан[9] бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцтай холбоотой шийдвэрээс бусдыг иргэд, олон нийт татан авах боломжтой. Шүүхийн шийдвэр олон нийтэд ил болсноор шүүхэд олон нийт итгэх итгэд нэмэгдэх чухал нөлөө үзүүлж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс авсан “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” судалгаагаар шүүхээр үйлчлүүлсэн болон шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн 60.6 хувь өнөөдөр шүүх хэрэг маргааныг хуульд нийцүүлэн шударгаар шийдвэрлэж байна гэдэгт итгэдэг[10] гэж хариулсанаас үзэхэд шүүхийн шийдвэрийн ил байдал хангах талаар хийсэн ажлууд иргэдэд тодорхой хэмжээгээр хүрсэн нь харагдаж байна[11]. Мөн нийт шүүхийн цахим хуудас, и-мэйл хаяг, утас, факсын мэдээлэл авч болох бөгөөд шүүх хуралдааны зар, тойм зэргийг үзэх боломжтой. Шүүх байгуулах тухай хууль өөрчлөгдсөнтэй холбогдуулан шүүхийн цахим сан /www.shuukh.mn/-

гийн гурав дахь хувилбарыг баяжуулж ажиллуулснаар дараахь ач холбогдолтой болсон. Үүнд:

- Өөрийн эсхүл хариуцагчийн гэрийн хаягийг оруулахад эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн хувьд аль шүүхэд хандахыг зааж өгөх мөн тухайн шүүхийн холбогдох бүх мэдээллийг хүргэх;
- Иргэний эрх зүйн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргахад төлөх тэмдэгтийн хураамжийн дүн, хэрхэн тооцоолсон аргачлалыг харуулах;
- Нийт шүүхийн байршлыг шүүхийн төрөл, шатыг google map дээр маш ойлгомжтой сонгон харуулах;
- Мэдээлэл лавлагааны буланг шинээр хийснээр иргэний шүүхэд мэдүүлэх эрхийн талаарх цогц мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлж өгсөн[12].

Мөн нийт шүүхийн 105 шүүх хуралдааны танхимд дуу болон дүрс бичиж, архивлах тоног төхөөрөмж суурилуулснаар сонирхсон этгээд нээлттэй шүүх хуралдааныг шүүхийн байранд шууд үзэх, хэргийн оролцогчид бичлэгийг хуулж авах, прокурор, цагдаагийн байгууллага сургалтад ашиглах, давж заалдах шатны шүүх хуулбарлан авах, шүүхийн ёс зүйн хороо тухайн шүүгчид холбогдох шүүх хуралдааны бичлэгийг хуулбарлан авах зэрэг байдлаар ашиглах боломжтой болсон нь дэвшилттэй алхам болжээ[13]. Хэдийгээр шүүхийн шийдвэрийн ил тод байдал сайжирсан нь дэвшилтэй алхам болсон боловч хувь хүн, байгууллага, төрийн нууцтай холбоотой шийдвэрийн нууцлал, ялангуяа гэр бүлийн хүрээний маргаан зэрэг хувь хүний нууцтай холбоотой шийдвэрүүдийг олон нийтэд нээлттэй, ил тод байрлуулах эсэх нь зохистой эсэхэд анхаарах асуудлын нэг болоод байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2010 оны 39-р захирамжаар баталсан Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийг шүүхэд хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх үндсэн чиглэл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014-2020 онд хэрэгжүүлэхээр шүүх хуралдаан ил явуулах зарчмыг тодорхойлсон *“Шүүхийн шинэ менежмент хөтөлбөр”*, *“Шүүх ба олон нийт”* зэрэг дэд хөтөлбөрийг 2014 онд баталсан. Шүүхийн үйлчилгээг үр нөлөөтэй, бүтээмжтэй, хариуцлагатай хэрэгжүүлэхүйц дэд бүтцийг бүрдүүлэх, олон талт программ хангамжийн тогтолцоог бүрдүүлэх, техник хангамж, сүлжээний найдвартай ажиллагааг хангах, мэдээлэл, харилцаа, холбоо, технологийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 111-р тогтоолоор *“Шүүхийн шинэ менежмент”* хөтөлбөрийг 2014-2020 онд хэрэгжүүлэхээр баталсан байна. Тус хөтөлбөрийн олон талт программ хангамж гэсэн зорилгод цахим хэлбэрээр шүүх хуралдааныг үзэх, нэхэмжлэл, тайлбар гаргах, шүүх хуралдаанд зайнаас оролцох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг хэргийн оролцогчид онлайнгаар мэдэх, и-мэйл, мессеж, гар утасны аппликейшн хэлбэрээр мэдээлэл илгээх бололцоог бүрдүүлэх, шүүхийн нэгдсэн цахим сан /<https://shuukh.mn/>-гийн хэрэглээг нэмэгдүүлэх, хялбар, хүртээмжтэй болгох /*бүх төрлийн таблет, ухаалаг гар утасны аппликейшн хувилбар гаргах, цахим санг олон нийтэд шаардлагатай мэдээллээр /бичиг баримтын загвар, улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ/* тогтмол

өргөжүүлэх, олон нийтэд тусгай дугаарын утсаар зөвөлгөө, лавлагаа өгөх үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор www.shuukh.mn вэбсайтыг дахин баяжуулалт хийгдэж олон нийтэд зориулж нэхэмжлэлийн загвар, нэхэмжлэлийн бүрдүүлбэр, нэхэмжлэлийн үнэ, улсын тэмдэгтийн хураамж, давж заалдах гомдол, эвлэрүүлэн зуучлал, шүүх хуралдааны дэг, шүүхийн ажиллагаа, шүүх хуралдааны нийтлэг журам зэрэг загваруудыг татаж авч хэрэглэх ач холбогдолтой.

Шүүхийн үйлчилгээг ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох, олон нийтийн хяналтыг тогтоох нөхцлийг бүрдүүлэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх ажлыг цогц, нэгдсэн бодлоготой төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2014 оны 114-р тогтоолоор *“Шүүх ба олон нийт”* хөтөлбөрийг 2014-2016 онд хэрэгжүүлэхээр баталжээ. Шүүх ба олон нийт хөтөлбөрт шүүх хуралдааны нээлттэй байдлын хүрээг улам нэмэгдүүлэх зорилтын хүрээнд нийт шүүхийг улам нээлттэй болгож, шүүх хуралдааныг зайнаас үзэх техникийн бололцоог шийдвэрлэх зорилгоор цахим шүүх хуралдааныг зохион байгуулж байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн, олны анхаарал татсан хэргийн шүүх хуралдааны бичлэгийг цахим хуудсанд байршуулах, шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим систем www.live.shuukh.mn цахим хуудсыг шүүхүүд 2015 оноос үе шаттай нэвтрүүлж ажилснаар 71023 шүүх хуралдааныг цахимаар зохион байгуулаад байна[14]. Тус хөтөлбөрийн шүүх, шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгах механизм тогтоох зорилтын хүрээнд шүүн таслах болон шүүхийн захиргааны ажлын тайланг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн вэбсайтаар дамжуулан олон нийтэд ил тод, хүртээмжтэй тогтмол мэдээлж хэвшжээ.

Шүүх, хуулийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэн мэдээлэл авах, хянах, үйл ажиллагаанд оролцох боломжтой болж байгаа мэдээллийн нэгдсэн сан Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сан www.e-justice.mn сайтыг 2018 оноос ажиллуулж эхэлжээ. Энэхүү систем нь гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл гаргагч иргэн болон мөрдөх байгууллага, прокурор, шүүхийн шатанд шалгагдан, шүүгдэж байгаа иргэдэд тухайн хэргийн хүрээнд өөрт хамааралтай бодит мэдээллийг цаг тухайд хүргэх, хууль, эрх зүйн тусламж өгөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессыг таниулах зорилго бүхий иргэний портал систем юм. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санд шүүх эрүүгийн хэрэг хүлээн авсан, шийдвэрлэсэн байдлын шийдвэрийн төрөл, гэмт хэргийн төрөл, төрийн санд оруулсан орлого, ял шийтгэл, таслан сэргийлэх арга хэмжээний санал, шийдвэрлэлт, зөрчил хүлээн авсан, шийдвэрлэсэн байдал зэрэг шүүхийн мэдээллүүд байршуулсан байдаг. Мэдээллийн нэгдсэн сангийн тусламжтайгаар *“Шүүх, хуулийн байгууллага үйлчилгээгээ хүртээмж, бүтээмж, үр нөлөө, хариуцлагатай хэрэгжүүлж байна”* гэдгээр үйл ажиллагаагаа хэмждэг болсон. Шүүх, хуулийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санд буй мэдээллээс олон нийт болон иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдод хамаарах хууль тогтоомжоор хориглоогүй мэдээллийг өгдөг. Иргэний энэ портал сайт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын мэдээллийг иргэнд хурдан, шуурхай, хүртээмжтэй хүргэх, иргэд олон нийтэд гэмт хэргийн статистикийн үнэн

бодитой мэдээлэл өгөх, хуулийн байгууллагуудын ил тод байдал болон хүний эрхийг хангахад чухал ач холбогдолтой.

2019 онд нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт *“Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно”* гэсэн заалт нь Шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, хүртээмжтэй болгох, шүүгчийн ачааллыг тэнцвэржүүлэх үр өгөөжтэй. Үндсэн хуулиар шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх цорын ганц субъектын хувьд шүүхэд мэдүүлэх иргэний эрхийг хангах, улмаар зөрчигдсөн эрх, эрх чөлөөг нь хамгаалах, шүүхийн үйлчилгээг нийгэм, иргэддээ чанартай, ил тод, хүртээмжтэй үзүүлэх үүрэгтэй.

2019 онд нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.6 дэх хэсэгт *“Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцуулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно”* гэсэн заалт нь Шүүхийн сахилгын хороог Үндсэн хуульд шинээр зааж өгч байгаа нь шүүгчийн хариуцлага, сахилгын тогтолцоог тогтвортой, тодорхой болгосон зохицуулалт болсон билээ. Ингэж шүүгчид хариуцлага хүлээлгэх асуудлыг бие даасан хараат бус байгууллага эрхлэх болсноор, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх үр дүнтэй.

2021 онд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай шинэчилсэн найруулга хуулийн *“Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмыг Шүүхийн Ерөнхий зөвлөл батална”* гэж шүүх хуралдааныг нээлттэй явуулах үүргийг тодорхой субъектэд хүлээлгэж, тус хуулийн 12.3-д *“Хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хуралдааны явцын дууны, дуу-дүрсний бичлэгийг зохих журмын дагуу баталгаажуулж, архивт хадгална”* мөн хуулийн 12.4-д *“Шүүх өөрийн цахим хуудастай байх бөгөөд шийдвэр, үйл ажиллагаага олон нийтэд тогтмол мэдээлнэ”* гэж шүүхийн шийдвэрийг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх ажлыг хуульчилжээ.

Монгол Улсын Шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 17 дугаар зүйлд *“Ерөнхий шүүгч Шүүхийн практик, тоон мэдээлэлд үндэслэн шүүн таслах ажиллагааны чанар, үр дүн, хэргийн хөдөлгөөний ерөнхий удирдлага, хяналтын талаар Шүүгчдийн зөвлөгөөнд мэдээлэл хийх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”* гэж хуульчилсан.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм[15] -ийн 15.11-т *“Шүүхээр хянан шийдвэрлэж байгаа хэрэг, маргааны талаар мэдээлэх гэсэн зохицуулалт байх бөгөөд дор дурдсанаас бусад тохиолдолд шүүгч нь шүүхэд шийдвэрлэгдэх гэж байгаа эсхүл шийдвэрлэгдэх магадлалтай хэрэг, маргааны талаар олон нийтэд мэдээлэл хийхийг хориглоно”*: Үүнд:

- Хэрэг, маргааныг шударгаар шийдвэрлэхэд саад болохгүй, эсхүл үр дүнд нөлөөлөхгүй хэмжээнд хичээл заах, судалгааны ажил хийх, өгүүлэл, ном бичих, илтгэл тавих зэргээр мэдээлэл хийх;
- Тодорхой хэрэг, маргаантай холбогдолгүйгээр шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тайлбарлах;
- Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл эсхүл бусад арга замаар өөрийнх нь үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан буруутгалд хариу өгөх;
- Өөрөө хувь хүнийхээ хувьд хэргийн оролцогчоор оролцож байгаа хянан шийдвэрлэх ажиллагаанд тайлбар хийх.

Шүүхийн Ерөнхий Зөвлөл 2017 оноос хэрэгжүүлж буй шүүхэд үйлчилгээний соёл нэвтрүүлэх ажлын хүрээнд шүүхийн үйлчилгээг сайжруулах зорилгоор “Чанарын удирдлагын тогтолцоо-MNS ISO9001: 2016 стандарт”-ыг шүүхийн Тамгын газруудад бүрэн нэвтрүүлж[16] ажиллах хэрэгтэй байна. Цахимаар зарласан шүүх хуралдаан хойшлох, шүүх хуралдааны дэг зөрчигдөх, хэргийн оролцогчийн эрх хөндөгдөх зэрэг сөрөг үр дагаврууд гарах, хуралдаан үр дүнгүй болох эрсдэл үүсэж эхлээд байсан тул энэ харилцааг нарийвчлан зохицуулсан эрх зүйн акт болох “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам”-ыг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 3-р сарын 31-ний өдөр анх удаа баталлаа. Энэхүү журмыг баталнаар шүүх хуралдааныг онлайнаар явуулах харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэж, шүүх хуралдаанд зайнаас болон цахимаар оролцох боломжтой боллоо. Шүүх хуралдаанд зайнаас буюу цахимаар оролцуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай явуулах, шүүх хуралдаан хойшлуулахгүй ач холбогдолтой.

“Шүүгчийн хараат бус байдал үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнөөс дээгүүр биш. Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө ч бас шүүхийн хараат бус байдлаас дээгүүр биш”. Зөвхөн хувь иргэнд хамаатай асуудлыг биш, хууль юу вэ? гэдгийг тайлбарлаж байгаа учраас олон нийт шүүхийн процессийг мэдэх эрхтэй. Тиймээс Шүүхийн процесс ил тод байх тухай 2016 оны Стамбулын тунхагийн гол санаа нь *new public management* буюу шүүх нь ардчиллын институциуддээ хянагдах ёстой гэсэн байна. Өөрөөр хэлбэл, иргэний нийгэм болон хэвлэлийн эрх чөлөөндөө хянагдана гэсэн үг. Шүүх хуралдааныг ил явуулах зарчмыг хэрэгжүүлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглах нь чухал ач холбогдолтой. Шүүх хуралдааны явцыг шууд нэвтрүүлэх, сурвалжлага хийлгэх, шүүхийн тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэлийг хэвлэн нийтлэх, шийдвэрлэсэн хэргийн тойм тайлбарыг гаргах зэрэг ач холбогдолтой. Америкийн Нэгдсэн Улс гэх мэт ардчилал хөгжсөн орнуудад илүү консерватив буюу *“Шүүгчийн хариуцлагыг шүүх өөрөө хянах ёстой”* гэх үзэл давамгайлдаг бол ардчиллыг шинээр тогтоосон болон сэргээн тогтоосон орнуудад иргэний нийгмийнхээ хяналтыг илүү чухалчилдаг байна. Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг иргэдийн өмнөөс эдэлж, мэдэх эрхийг нь хангадгийнхаа хувьд хэн нэгний хэвлэн нийтлэх эрх, шүүхийн хараат бус байдалд халдсан болохгүй.

Гадаадын зарим улс шүүн таслах ажиллагааны чанарыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан байдаг. Тухайлбал Финланд Улсад 1999-2005 онд *“Шүүх дэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарыг үнэлэх нь”*. Түүнчлэн Европын зөвлөлийн *“Шүүх засаглалын үр ашгийг дээшлүүлэх*

Европын комисс”-оос 2016 онд “*Шүүх засаглалын чанарыг хэмжих нь*” баримт бичгийг баталж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, шүүхийн шийдвэрийн чанар, шүүхийн үйлчилгээний чанарыг тус тус үнэлэхээр тусгаж, ингэхдээ чанарын шалгуур үзүүлэлтийг болон чанарын стандартыг тодорхойлохын чухлыг онцолжээ[17]. Шүүн таслах ажиллагааны чанарыг хэргийн оролцогчидтой харилцах харилцаа буюу тэдэнд хамааралтай хүний эрхэм чанарыг хүндэтгэх ёсоор хандах, шүүхийн ажиллагаа, шүүхийн шийдвэр, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, шүүгчийн мэргэшил, ур чадвар, хэргийн хөдөлгөөний зохион байгуулалт, шүүх дэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарыг сайжруулах зэргийг цогц байдлаар авч үзэх хэрэгтэй байна. Шүүн таслах ажиллагааны чанарыг нээлттэй, ил тод, хүртээмжтэй болгох, шүүхийн ачааллыг бууруулах, шүүхийн шийдвэрийг урьдчилан тооцоолох зэрэг шүүхийн хөгжилд олон талын ач холбогдолтой мэдээллийн технологи, хиймэл оюун ухааныг ашиглах боломжтой. Эрх зүйн соёл, ухамсар өндөр төлөвшсөн Европын улс орнууд хиймэл оюун ухааныг шүүхийн системдээ янз бүрийн түвшин чиглэлээр ашиглаж эхлээд байна. Европын зөвлөлийн шүүх засаглалын үр ашгийг дээшлүүлэх Европын комиссоос “*Хиймэл оюун ухааныг шүүхийн системд ашиглах болон холбогдох орчны талаарх Европын ёс зүйн тунхаг*”-ийг 2018 онд баталжээ. Энэхүү тунхагт хиймэл оюун ухааныг шүүхийн системд ашиглахад баримтлах зарчмуудыг тусгаж, шүүхийн системд шат дараалалтай нэвтрүүлэхийн ач холбогдлыг онцолсон. Хиймэл оюун ухааныг ашиглах чиглэлүүдийг төрөлжүүлж “*Хөхиүлэн дэмжвэл зохих*”, “*Болгоомжтой хандвал зохих*”, “*Шинжлэх ухааны судалгааны үр дүнд авч үзвэл зохих*”, “*Онцгой анхааралтай хандах*” гэсэн түвшнүүдэд ангилж, зохих зөвлөмжүүдийг өгсөн байна[18]. Шүүхийн шийдвэрийн цахим хуудаст нийтэд ил нээлттэй байгаа 280 гаруй мянган хэргийн 380 гаруй мянган шүүхийн шийдвэрийн ашиглалт, хайлт, хэрэглээг төгөлдөржүүлж, хиймэл оюун ухаанруу хөрвүүлэх, хиймэл оюун ухаанаас гарах бүтээгдэхүүнийг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, шүүхийн шийдвэр гэнэтийн үзэгдэл болдог байдлыг хангах, иргэд маргах асуудлынхаа шийдлийг урьдчилан тооцоолох улмаар шүүхэд хандах эсэхээ шийдэх, шүүхийн ачааллыг бууруулах, үйлчлүүлэгчид хурдан шуурхай, итгэл хүлээхүйцээр үйлчлэх арга хэрэгсэл болгон ашиглах боломж байна. Шүүхийн системд хиймэл оюун ухааныг хэрэглэх, ашиглах ёс зүй, зарчим, үе шат, хөрөнгө, санхүү, хүний нөөцийн хуваарилалт, шүүхийн байгууллагуудын оролцоог шийдвэрлэх шаардлагатай байна.

Шүүх хуралдааны явцыг олон нийтэд шууд дамжуулах гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, туршлага, жишиг: Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг дамжуулах буюу ‘*trial by media*’ гэх ойлголт нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийгэмд үзүүлэх нөлөө нэмэгдсэнтэй холбоотой байдаг[19]. Шүүх хуралдааны бичлэгийг телевиз, радио зэрэг олон нийтийн хэвлэл мэдээлэл, сошиал медиагаар шууд дамжуулах асуудал нь ховор тохиолддог хэдий ч зарим тохиолдолд шүүгчийн шийдвэрээр шүүх хуралдааныг олон нийтэд шууд дамжуулахыг тодорхой нөхцөл, хязгаарлалтын хүрээнд зөвшөөрдөг байна.

Ихэнх тохиолдолд шүүгчид “Нээлттэй шүүх”[20]* зарчмыг цахим хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөнөөр дамжуулан, сурталчлах асуудалд болгоомжилсон байр суурьнаас ханддаг. Европын зөвлөлийн сайд нарын хорооноос 2003.07.10-ны өдөр баталсан 2003/13 тоот “Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах тухай”[21] зөвлөмжид нээлттэй шүүхийн эрх зүйн асуудлыг нэг бүрчлэн, дэлгэрэнгүй тодорхойлсон олон улсын эрх зүйн баримт бичиг гэж үзэж болохоор байна. Тус зөвлөмжөөс харахад нээлттэй шүүх нь зөвхөн шүүх хуралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах эсэх асуудлаас илүү өргөн агуулгатай бөгөөд шүүх, цагдаагийн алба ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн зохистой харьцааг хангах, ингэхдээ хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх тухай үзэл санаа юм.

Япон Улсын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд шүүх хуралдаан нээлттэй байх зарчмыг тусгасан байна. Энэ зарчим нь ихэвчлэн хаалттайгаас бусад шүүх хуралдааны явцыг үзэж сонирхох эрхийг иргэдэд олгосноор хэрэгждэг. Шүүх хуралдааны танхимд сонсогч иргэдэд зориулсан суудал байдаг бөгөөд иргэд хүсэлт гаргаснаар шүүх хуралдааны явцыг ажиглах, үзэх боломжтой байдаг. Шүүх хуралдааны явцын тухай бичлэг хийхдээ Ерөнхий шүүгчээс зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд бичлэг хийх хэвлэл мэдээллийн төлөөлөгч нь энэ асуудлыг урьдаас зохицуулж, зохих зөвшөөрлийг авсан байна. Нэг хуралд нэг л хүнд бичлэг хийхийг зөвшөөрөх бөгөөд жижиг оврын мэргэжлийн камер 1 ширхгийг хуралдааны танхимд оруулна. Эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд гагцхүү хохирогч байхгүй үед бичлэгийг хийж болно. Бичлэг хийх этгээд нь үзэгчдийн суудал талаас бичлэгийг хийнэ. Гагцхүү шүүгч, шүүгчдийн суудал, оролцогчдын суудал зэргийг дүрс бичлэгт буулгаж авахыг зөвшөөрнө. Зураг авах, бичлэг хийх зөвшөөрөл авсан этгээд нь шүүгчийг энэ ажиллагааг дуусгахыг шаардсаны даруйд бичлэг, зураг авалтаа шууд дуусгаж, шүүх хуралдааны танхимыг орхиж гарна. Бичлэг хийх хугацаа нь 2 минут байх бөгөөд энэ хугацаанд гагцхүү шүүгч танхимд орж ирэх, шүүх хуралдаан эхэлснийг зарлах хүртэлх хугацааг багтаана. Бичлэг хийх 2 минутын хугацаа нь дуусмагц бичлэг, зураг авалтыг нэн даруй зогсоох үүрэгтэй. Харин шүүх хуралдааныг үзэж сонирхсон этгээдээс яриа авах, болсон үйл явдлын тухай асууж болно. Түүнчлэн шүүх хуралдааны сүүлийн хэсгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж болно. Сүүлийн үед шүүх хуралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх нь шүүхийн нээлттэй байх зарчмыг бодитоор хэрэгжүүлэх явдал болж байна гэдэгтэй санал нэгдэх хуульчдын тоо нэмэгдэж байна.

Бүгд Найрамдах Солонгос улсын Шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1-5 дугаар хэсгүүдэд шүүх хуралдааныг олон нийтэд шууд нэвтрүүлэх талаар тодорхой зохицуулжээ[22]. Зарчмын хувьд шүүх хуралдаан ил тод, олон нийтэд нээлттэй байх ёстой боловч энэ нь аль шүүхэд хэргээ шийдвэрлүүлж байгаагаас ихээхэн хамааралтай. Шүүгч дараах тохиолдолд олон нийтэд шүүх

* Нийтийн эрх зүйд ‘open court’ буюу “нээлттэй шүүх” гэдэгт олон нийт шүүх хуралдааныг нээлттэй байлгах эрхтэй холбон ойлгодог. Тодруулбал, шүүхийн үйл ажиллагаа нь түүнийг ажиглагч этгээдэд чөлөөтэй, нээлттэй байх нээлттэй шүүхийн шинжийг ойлгоно.

хуралдааныг шууд нэвтрүүлэхийг зөвшөөрч болно. Шүүхийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байгааг мэдэх нь ард түмний үндсэн эрх юм[23]. 2015 оны 9 дүгээр сарын 18-нд Бүгд Найрамдах Солонгос улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Янг Сунг-тэ нь *“Супермаркетын ажиллах цагийн хуваарийн хязгаарлалтын талаарх шүүх хурал”*-ыг шууд нэвтрүүлэхээр шийдвэр гаргасан байна. Тус шүүх хурлыг Дээд шүүхийн цахим хуудас, цахим портал *“Naver”*-ээр шууд нэвтрүүлж, түүнчлэн Солонгосын үндэсний телевизээр нэвтрүүлсэн байна. Бүгд Найрамдах Солонгос улсын Дээд шүүхээс шүүх хуралдааны явцыг шууд нэвтрүүлэх нь иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэхээс гадна олон нийтийн зүгээс шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай танилцах боломжийг олгоно гэж үзжээ. Улмаар Бүгд Найрамдах Солонгос улсын Дээд шүүхээс иргэд, олон нийтэд шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод явуулах үүднээс тодорхой хэргүүдийн шүүх хуралдааныг шууд нэвтрүүлж байхаар болсон байна[24].

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулийн үндсэн хэсгийн 16, тэр дундаа 16 (1) (а)-д хүн бүр хэвлэл болон бусад хэвлэл мэдээллийн эрх чөлөөг багтаасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүнчлэн мэдээлэл, үзэл санаа, хүлээн авах эсвэл түгээх эрх чөлөөг баталгаажуулсан байна[25]. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 152 дугаар зүйлд *“Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид зааснаас /Хүүхдийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн хэргийг шаардлагатай тохиолдолд хаалттай шүүх хуралдаанаар явуулдаг/ бусад тохиолдолд нээлттэй хуралдаан хийж болно”* гэж заасан байна[26]. Эрүүгийн хэргийн шүүх хурлыг олон нийт болон дэлхий дахинд нээлттэй CNN, BBC болон бусад мэдээллийн сувгаар цацсан шүүх хурал бол 2012 оны Лондонгийн Параолимпийн гүйлтийн аварга Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын иргэн Оскар Писториусын хүн амины гэмт хэрэгт сэжиглэгдсэн хэрэг юм. Оскар Писториусын шүүх хуралдааныг олон нийт, дэлхий дахинд шууд нэвтрүүлэхийг зөвшөөрсөн шүүгч Токозиль Масипа шийдвэртээ дараах үндсэн эрх болон хязгаарлалтуудыг тусгасан байна. Үүнд, Үндсэн хуулийн эрхийг хангах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шударга шүүхээр шүүлгэх эрх, шүүх хуралдаан нээлттэй байх зарчим болон Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хэрэгжүүлэх зорилгоор шүүх хурлыг бүрэн дуу, хязгаарлагдмал дүрс бичлэг, дуу болон дүрс зургийн хэлбэрээр дамжуулахыг зөвшөөрсөн байна[27]. Дээр дурдсан улсуудын практикаас харахад шүүх хуралдааны явцыг зураг болон дүрс бичлэгт буулган авч, олон нийтийн дунд нэвтрүүлэх явдлыг сүүлийн үед дэмжих хандлагатай байна. Харин шүүх хуралдааны хэргийн оролцогчдын хувь хүний нэр хүнд, нууц, шүүхийн аюулгүй байдлыг хангах зэрэг зорилгоор хуулийн хүрээнд шүүгч шийдвэртээ тодорхой үндсэн эрхийг ханган мөн тодорхой хязгаарлалтуудыг маш нарийн тусгаж, шүүх хуралдааныг шууд дамжуулан нэвтрүүлэхийг зөвшөөрдөг байна.

III. Судалгааны үр дүн

Тоон судалгааны шинжилгээ: Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг ил явуулах эрх зүйн зохицуулалттай. Гэвч ажиглалтын явцад ил шүүх хуралдаанд жирийн иргэд чөлөөтэй нэвтрэн орох боломжийг хязгаарласан нь ажиглагдаж байсан. Тухайлбал, шүүх хуралдааны танхимд

жирийн иргэд, ажиглалт хийж буй оюутнууд саадгүй нэвтрэн орохыг татгалзсан тохиолдол нийт ажигласан хурлын 20 хувийг эзэлж байна. Ил шүүх хуралдаанд саадгүй нэвтрэн орох эрхийг хязгаарласан тохиолдлын шалтгааныг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 1. Ил шүүх хуралдаанд оролцох эрх хангагдсан байдал[28]
(2010 оны судалгааны дүнтэй харьцуулсан байдлаар)*

Асуулт	2010 он	2015 он
Шүүх хуралдаанд оролцох хүсэлтэй хүн бүрийг оруулсан	92.2%	91.2%
Шүүх хуралдаанд оруулсан хэдий ч тусгайлан зөвшөөрөл авах хэрэгтэй байсан	66.2%	23.3%

2010 онд хийсэн анхны ажиглалтын дүнтэй харьцуулахад тусгайлан зөвшөөрөл авах явдал буурсан үзүүлэлт харагдаж байна. Шүүх хуралд ороход 23.3 хувьд нь ямар нэг зөвшөөрөл шаардаж байгаа нь шүүх хуралдааныг ил явуулах зарчим бүрэн хэрэгжиж байна гэж дүгнэх боломжгүй бөгөөд ил байдал хангалтгүй байгааг илтгэж байна. Ил шүүх хуралдаанд оролцох зөвшөөрлийг 2.8 хувь нь шүүгчээс, 33.3 хувь нь шүүхийн нарийн бичгийн даргаас, 25.0 хувь нь шүүхийн тахараас, 38.9 хувь нь шүүхийн захиргааны бусад ажилтнаас авсан байна.

Хүснэгт 2. Ажиглалтад хамрагдсан шүүх хуралдааны тархалт[29] (шүүх тус бүрээр)

№	Шүүхийн нэр	Шүүх хуралдааны хувь
1	Дүүргийн 1-р шүүх	38%
2	Сум дундын 10-р шүүх	19%
3	Сум дундын 23-р шүүх	19%
4	Сум дундын 27-р шүүх	24%

Эрүүгийн анхан шатны 4 шүүх дээр нийт 159 шүүх хуралдааны явцад ажиглалт хийснээс 62 хувь нь хөдөө орон нутгийн шүүхийн хурал байв. Орон нутгаас судлагдсан шүүх хуралдааны 24% нь Хөвсгөлд, 19 хувь нь Дорнодод, 19 хувь нь Төв аймагт болжээ. Шүүх хуралдаанд хөндлөнгийн ажиглагчийг оруулахгүй байгаа голлох шалтгаан нь:

- Шүүх хуралдааны танхимын багтаамж муу.
- Субъектив шалтгаан нөхцөл (шүүх хуралдааны нарийн бичиг, шүүхийн тахар, шүүгчийн туслахаас хүсэлт гаргах, зөвшөөрөл авахыг шаардах, тухайн хэрэгт хамааралгүй иргэнийг оруулахгүй гэх мэтээр ил шүүх хуралдаанд оролцох эрхийг хангаагүй).

2021 онд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай шинэчилсэн найруулга хууль батлагдахаас өмнөх үетэй харьцуулахад шүүхийн ил тод, нээлттэй байдал сайжрах эрх зүйн үндэс бүрэлдсэн гэж үзэж болохоор байна. Хэдийгээр шүүхийн ил тод, нээлттэй байдлын эрх зүйн зохицуулалт өмнөх үетэй харьцуулахад сайжирч байгаа боловч практикт энэ зохицуулалтын хэрэгжилт зарим талаар сул байгаа талаар судалгаа гарчээ. Тухайлбал, судлаач П.Баттулга нарын 2017 онд хийсэн “Шүүх хуралдааны ажиглалт” судалгаанд: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 235 дугаар зүйлийн 235.1 дэх хэсэгт “Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах болон насанд хүрээгүй этгээдэд

холбогдох хэрэг хянан шийдвэрлэхээс бусад тохиолдолд шүүх хуралдааныг нээлттэй явуулна” гэж тусгасан боловч энэ заалтын хэрэгжилт сул байна. Нээлттэй шүүх хуралдаанд ажиглагчаар оролцохыг хүссэн иргэн бүрийг ямар нэгэн зөвшөөрөл шаардахгүйгээр шүүх хуралдаанд оролцуулах, ингэхдээ шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах үүднээс зөвхөн бичиг баримт, шаардлагатай тохиолдолд биедээ авч яваа эд зүйлийг шалгаж нэвтрүүлэх учиртай. Ажиглалт хийсэн эрүүгийн хэргийн нийт шүүх хуралдаанаас үзэхэд шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчим бүрэн хэрэгжиж байна гэж дүгнэх боломжгүй байна. Ажиглалтын дүнгээс харахад 76.6 хувьд нь ажиглагчдыг шүүх хуралдааны танхимд саадгүй нэвтрүүлж, 22.7 хувьд нь биеийн байцаалтыг шалган оруулж, 2 шүүх хуралдаан буюу 0.7 хувьд нь ажиглагчдыг оруулахаас татгалзсан байна[30]. Үүнээс үзэхэд шүүх хуралдаан хориглосноос бусад тохиолдолд нээлттэй явагдах, шүүхийн шийдвэр нээлттэй байх гэсэн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангахад шүүх, шүүхийн Тамгын газрын ажилтнууд анхаарч ажиллах шаардлагатай болох нь уг судалгаанаас харагдаж байна.

Чанарын судалгааны шинжилгээ: Шүүх хэргийг ил таслан шийдвэрлэсэн кэйс жишээг шигтгээ байдлаар давхар оруулж өгсөн нь илүү бодитой дүр зургийг харуулахад тусалсан.

Жишээ 1: Хадгаламж зээлийн хоршоодын гэх цуврал шүүн таслах процессууд эхэндээ ил явагдсан. Бодит байдалд шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах хүч дутагдсан уу, эсхүл түүгээр шалтаг хийе гэж бодсон уу, ерөөсөө шүүгчид айсан уу шүүх хуралдааныг ил нэрийн доор хаалттай бүсэд явуулсан. Энэ хэрэг дээр шүүх хуралдааны аюулгүй байдал алдагдаж, ил явуулах зарчим зөрчигдсөн гэж үздэг.

Жишээ 2: Н.Энхбаяр, Л.Гансүх нарын шүүх хурлыг хоёр удаа телевизээр шууд дамжуулсан бөгөөд “шүүх хуралдааныг шууд дамжуулах нь шүүгчийн хараат бус, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай. Шүүгчийг олон нийтийн сэтгэл зүйд тааруулж шийдвэр гаргахад түлхэж байна” гэх болгоомжлол шүүгчид, шүүхүүдийн зүгээс, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн зүгээс ч удаа дараа сонсогдсон. Манайд “шүүх хуралдаан иргэдэд нээлттэй” гэх боловч шүүхийн танхим руу нэвтрэхийн тулд ихэнх тохиолдолд хэн нэгний зөвшөөрөл шаарддаг. Шүүх хуралдааныг сурвалжлагаар очсон сэтгүүлчдээс ч гэсэн урьдчилж заавал зөвшөөрөл авсан байхыг шаарддаг. Тэгээд олны анхааралд өртсөн дуулиантай хэргүүдийг ихэнхдээ ямар нэг шалтгаанаар хаалттай явуулж, “нууц”-ад хамруулдаг.

IV. Хэлэлцүүлэг

Улс төр, эрх зүйн салбарын онол, арга зүйн хэлэлцүүлгээр эрдэм шинжилгээний өгүүллийг хэлэлцүүлж сэдвээ нарийвчилан томъёолж, судалгааны хамрах цар хүрээгээ хумиж тодорхой болгож, судалгааны чиг баримжаагаа олсон. Хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийн дагуу Шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчмын хэрэгжилтийг нарийвчилан судалж, холбогдох судалгаагаар өгүүллээ баяжуулсан. Ил шүүх хуралдаанд оролцох эрх хангагдсан байдал 2010 онд хийсэн анхны ажиглалтын дүнг 2015 оны судалгаатай харьцуулахад тусгайлан зөвшөөрөл авах явдал 1 хувиар буурсан үзүүлэлт харагдаж байгаа боловч шүүх

хуралд ороход 23.3 хувьд нь ямар нэг зөвшөөрөл шаардаж байгаа нь шүүх хуралдааныг ил явуулах зарчим бүрэн хэрэгжиж байна гэж дүгнэх боломжгүй бөгөөд ил байдал хангалтгүй байгааг илтгэж байна. Иймээс цаашид нээлттэй шүүхээр шүүлгэх эрхийн стандартын хэрэгжилтийн ажиглалтын үйл ажиллагааг тогтмол, үр нөлөөтэй явуулах шаардлагатай байна.

Судлаачийн дэвшүүлсэн эл өгүүллийн хэлэлцүүлгээс дараах саналуудыг дэвшүүлсэн болно.

- Цахим баримтыг хэрэглэх тухай хууль баталж хэрэгжүүлэх
- Цахим хавтаст хэргийн тухай хууль батлуулах
- Цахим шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын тухай Улсын дээд шүүхийн тогтоол баталж хэрэгжүүлэх
- Шүүх дэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарыг сайжруулах шалгуур үзүүлэлт болон чанарын стандартыг боловсруулж нэвтрүүлэх
- Шүүхийн үйлчилгээ, шүүн таслах ажиллагаанд мэдээлэл, технологийн дэвшлийг ашиглаж иргэд, олон нийтэд нээлттэй цахим шүүх болох бодлого баримтлан ажиллах
- Нэхэмжлэл, хариу тайлбар, нотлох баримт зэргийг цахимаар шүүхэд гаргадаг болох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай баримт материалыг цахимаар хүргүүлэх, хүлээн авах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахимаар хяналт тавих, e-Filing, e-Case management-ийг нэвтрүүлэхэд шаардлагатай цахим шүүхийн нэгдсэн системийг зохиох, хөгжүүлэх ажлыг шат дараалалтай авч хэрэгжүүлэх
- Цахим шүүх хуралдааныг зохион байгуулахад шаардлагатай мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг хангалттай түвшинд нийлүүлэх, мэргэжилтнийг бэлтгэж, сургаж, байнгын ажиллуулах
- www.shuukh.mn цахим мэдээллийн сайтыг хөгжүүлж, шүүх хуралдааны бичлэгийг ил болгох, цахимаар үздэг болох
- Хиймэл оюун ухааныг шүүн таслан ажиллагааны чанарыг сайжруулахад хэрэгсэл болгон ашиглах
- Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад шударга шүүхийн болон олон нийтийн өмнө ил шүүлгэх эрхийн ойлголт стандартыг олгох сургалт явуулах
- Шүүх, шүүх хуралдааны ил байдлыг хангахад чиглэсэн нарийвчилсан стандарт, журмыг боловсруулж шүүх бүрт нэг мөр мөрдүүлэх
- Иргэдэд шүүх хуралдаанд хэрхэн оролцох талаар болон шүүх хуралдааны дэгийг танилцуулсан мэдээллийг бэлтгэж олон нийтэд хүртээмжтэй газар байршуулах
- Шүүхийн цахим хуудсын хөтлөлтийг идэвхжүүлж, иргэдэд шаардлагатай мэдээллээр баяжуулах, шүүх хуралдааны товыг тогтмол зарлахдаа ил зарлагдсан эсэх талаар оруулдаг байх
- Шүүн хуралдааны ил болон хаалттай явуулах зарчмын асуудлуудын уялдаа холбоо, зааг ялгааг зөв зүйтэй тодорхойлох
- Шүүн хуралдааны ил явуулах зарчмыг хангахтай холбоотой дүрэм, журмуудад шүүх хуралдааны танхимын стандартуудыг тусгаж шинээр боловсруулах

- Нээлттэй шүүхээр шүүлгэх эрхийн стандартын хэрэгжилтийн ажиглалтын үйл ажиллагааг тогтмол, үр нөлөөтэй явуулах
- Шүүх хуралдааны хэргийн оролцогчдын хувь хүний нэр хүнд, нууц, шүүхийн аюулгүй байдлыг хангах, хуулийн хүрээнд шүүгч шийдвэртээ тодорхой үндсэн эрхийг ханган, тодорхой хязгаарлалтуудыг маш нарийн тусгаж, шүүх хуралдааныг шууд дамжуулан нэвтрүүлэхийг зөвшөөрдөг болох
- Эрх зүйг дээдлэх ёс төлөвшин тогтож, иргэдийн итгэлийг баттай хүлээсэн шударга, ил тод шүүхийн тогтолцоог төгөлдөржин хөгжүүлэх

VI. Дүгнэлт

Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчмыг нийгмийн хөгжлийн болон технологийн дэвшил хурдацтай хөгжиж байгаа эрин зуунд хууль, эрх зүйн талаас нь улам бүр төгөлдөржүүлэх шаардлага ямагт нэн тэргүүнд тавигдаж байна. Төрийн байгууллагын тогтолцооны дээд шатанд алба хашиж буй хүмүүсийн үйл ажиллагаатай холбогдсон янз бүрийн хэрэг, зөрчил, өндөр албан тушаалтны нэр холбогдсон олон түмний санаа сэтгэлийг хямруулж буй “*Дуулиант*” хэрэг зөрчлүүдийг хуулийн дагуу ил, шударга, шуурхай шийдвэрлэж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж байх нь шүүх засаглалын харилцааг эрүүлжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой.

2021 онд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай шинэчилсэн найруулга хууль батлагдсанаас өмнө үйлчилж байсан хуулиудтай харьцуулахад шүүхийн ил тод, нээлттэй байдал болон түүний эрх зүйн орчин сайжирч байгаа гэж үнэлж болохоор байна. Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг зохицуулсан Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр, шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах хөтөлбөр, Монгол Улсын шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал, шүүхийн мониторингийн үзэл баримтлал, Шүүхийн шинэ менежмент хөтөлбөр, шүүх ба олон нийт хөтөлбөр зэрэг эрх зүйн баримт бичгийг батлан хэрэгжүүлж ирсэн нь дэвшилттэй алхам болжээ.

Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр болон эрх зүйн баримт бичгийг боловсруулж батлан гүнзгийрүүлэх, эрх зүйн зохицуулалтыг нь нарийвчилан сайжруулах, шүүхийн шийдвэрт анилиз, дүгнэлт хийх, судалгааны эргэлтэд оруулах нь шүүхийн цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой.

Ашигласан материал

1. Даваажав Б. (2010). Шүүх хуралдааны аюулгүй байдал ба шүүх хуралдаан нээлттэй явуулах хууль зүйн харилцан хамаарлын зарим асуудал. ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр. Уб.,

2. Даваажав Б. (2010). Шүүх хуралдааны аюулгүй байдал ба шүүх хуралдаан нээлттэй явуулах хууль зүйн харилцан хамаарлын зарим асуудал. ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр. Уб., 27 дахь тал
3. Улсын Их Хурлын 1998 оны Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах тухай 18 дугаар тогтоол
4. Монгол Улсын Их Хурлын 2000 оны 39 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”. Уб.,
5. Монгол Улсын Их Хурлын 2000 оны 39 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”. Уб.,
6. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сайт. <https://legalinfo.mn/mn.2022.06.25>
7. Улсын Их Хурлын 2003 оны Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай 41 дүгээр тогтоол
8. Шүүхийн цахим сангийн албан ёсны сайт. <http://old.shuukh.mn>
9. Шүүхийн цахим сангийн албан ёсны сайт. <https://shuukh.mn/.2022.06.25>
10. Шүүхийн ерөнхий зөвлөл. (2016). Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 оны тайлан. Уб.,
11. ХЗҮХ, Германы хамтын ажиллагаа. (2016). Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь. Хавсралт тайлан. Уб., 101 дэх тал
12. Шүүхийн ерөнхий зөвлөл. (2016). Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 оны тайлан, <http://www.judcouncil.mn/> Уб., 30 дахь тал.
13. ХЗҮХ. (2018). ууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварыг үнэлэх үнэлгээний тайлан. Уб., 31 дэх тал
14. Шүүхийн цахим сангийн албан ёсны сайт. <https://live.shuukh.mn/#gsc.tab=0.2022.06.25>
15. Монголын Хуульчдын холбоо. (2013). Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм. Уб.,
16. Өлзийсайхан Б. (2022). Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого. эрдэм шинжилгээний илтгэл. Уб., 11 дэх тал
17. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2021 оны 10-р сарын 15-ны өдөр зохион байгуулсан Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын үндэсний чуулганд хэлэлцүүлсэн УДШ-ийн Ерөнхий шүүгч Д.Ганзоригын “шүүхийн шинэтгэл: бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага” сэдэвт илтгэл.
18. Дурдсан илтгэл.
19. Effect of trial by media before courts <http://www.lawteacher.net/free-law-essays/commercial-law/effect-of-trial-by-media-before-courts-law-essay.php>
20. West’s Encyclopedia of American Law, edition 2. Copyright 2008 The Gale Group, Inc. <http://legal.dictionaty.thefreedictionary.com/Open+Court>
21. About the Committee of Ministers http://www.coe.int/T/CM/aboutCM_en.asp
22. General principles of the Court http://united-korea.org/code_judicial/article_0310.htm
23. Supreme court of Korea http://united-korea.org/code_judicial/article_0310.htm
24. <http://eng.scourt.go.kr/eboard/NewsListAction.work?gubun=41&pr=1>
25. Constitution of the Republic of South Africa, 1996 - Chapter 2: Bill of Rights - 210
26. Criminal procedure act 51 of 1977 <http://www.justice.gov.za/legislation/acts/1977-051.pdf>

27. South Africa: North Gauteng High Court, Pretoria.
<http://www.saflii.org/za/cases/ZAGPPHC/2014/37.html>- 211
28. ННФ. (2015). Шүүх хуралдааны ажиглалт. Судалгааны нэгдсэн тайлан. Уб., 15 дахь тал
29. ННФ. (2015). Шүүх хуралдааны ажиглалт. Судалгааны нэгдсэн тайлан. Уб., 27 дахь тал
30. Баттулга П., ба бусад. (2017). Шүүх хуралдааны ажиглалт. судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. Уб., 11 дэх тал

Санхүүжилт. Хууль зүй, дотоод хэргийн яамны “Үндсэн хуулийн үзэл баримтлал, тогтвортой хөгжлийн бодлогын үр дүн” сэдэвт захиалагт төслийн хүрээнд уялдуулж энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийг бичсэн болно.

Талархал. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл бичихэд мэргэжил, арга зүйн зөвөлгөө, зөвлөмж өгч, чиглүүлсэн Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажилтнуудад талархал илэрхийлье.